

2015 оны 05 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Хурлын ирц: 100%

Хуралд оролцсон шинээр томилогдсон гишүүдийн нэрс:

1. Эльер Хасанов
2. Г.Оюунболд
3. Б.Өлзийбаяр
4. М.Төвшин
5. Д.Үнэнбат
6. Камолиддин Талипов
7. С.Батбилэг
8. Д.Батсайхан
9. Ц.Мэндбаяр

Хурлаар хэлэлцсэн асуудлуудын жагсаалт:

1. ТУЗ-ийн даргыг сонгох
2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг сонгох
3. ТУЗ-ийн хороодыг байгуулах, хороодын дарга болон гишүүдийг томилох
4. Гүйцэтгэх захирлыг томилох
5. Бусад

“Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2015 оны 05 сарын 07-ны өдөр Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпын гудамж, Реженс Резиденс байрны 3 давхарт 314 тоот өрөөнд 11 цаг 00 минутанд эхлэв.

Гүйцэтгэх захирал Мэндийн Төвшин тус хурлыг эхлүүлж, хэлэлцэх асуудлуудыг ТУЗ-ийн гишүүдэд танилцуулав.

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- Төлөөлөн Удирдах зөвлөлийн хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа. 2015 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал маань амжилттай явагдсан билээ мөн тус хурлаар сонгогдсон 2 шинэ гишүүн, улиран солигдсон бусад гишүүддээ баяр хүргэе.

“Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ний ТУЗ-ийн гишүүн болсноор манай компанид үнэтэй хувь нэмэр оруулана гэдэгт итгэж байна.

Өнгөрсөн жил ТУЗ-ийн дарга асан Алишер Али маань Монголд байнга оршин суудаггүй учраас ТУЗ-ийн гишүүн болон даргаар ажиллах боломжгүй болсон. Жим Двайер гишүүний хувьд өөр ажил үүрэгтэй давхацсан, сонирхлын зөрчил үүссэн гэдэг шалтгаанаар энэ жил нэр дэвшээгүй. Шинээр сонгогдсон гишүүдийг одоо та бүхэнд танилцуулья. Цэвээний Мэндбаяр нь “Алтан Трейд” компанид Гүйцэтгэх захирлын албыг хашдаг. Дугарсүрэнгийн

Батсайхан “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ний Ерөнхий нягтлан бодогч хийдэг. Д.Батсайхан нь анх компани байгуулагдсан цагаас хойш ажиллаж байгаа.

Одоо та бүхэнд хурлаар хэлэлцэх асуудлуудыг таницуулъя.

1. ТУЗ-ийн даргыг сонгох
2. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг сонгох
3. ТУЗ-ийн хороодыг байгуулах, хороодын дарга болон гишүүдийн томилох
4. Гүйцэтгэх захирлыг томилох
5. Бусад

Нэгдүгээр асуудал болох ТУЗ-ийн даргыг сонгох асуудлын талаар ярилцъя.

ТУЗ-ийн гишүүн Камолиддин Талитов:

- Юуны өмнө шинэ гишүүддээ баяр хүргэе. Миний хувьд Эльер Хасановыг санал болгомоор байна. Та нар юу гэж бодож байна? Хэрвээ эсэргүүцэх зүйлгүй бол саналаа хураацгаая.

ТУЗ-ийн гишүүд:

- Зөвшөөрч байна. Бидэнд эсэргүүцэх зүйл байхгүй.

ТУЗ-ийн дарга Эльер Хасанов:

- Итгэл хүлээлгэсэн та бүхэнд баярлалаа. ТУЗ-ийн даргын ажил үүргийг амжилттай хэрэгжүүлж ажиллахын тулд өөрийн чадах бүхнээ хийх болно. Одоо бүгдээрээ дараагийн хэлэлцэх асуудал болох ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг сонгох талаар хэлэлцэцгээе. Өмнөх жил Б.Мягмар ТУЗ-ийн нарийн бичгийн үүрэг даалгаврыг амжилттай хийж байсан билээ. Харин Б.Мягмар маань энэ жил жирэмсэний амралтаа авч байгаа тул үүрэгт ажилаа хүлээлгэн өгсөн. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гэдэг бол маш хариуцлагатай ажил. Тиймээс бид бүхэн хэлэлцэсэний эцэст Хаш-Эрдэнийн Амгаланбилэгийг нэр дэвшүүлмээр байна. Х.Амгаланбилэг нь Монгол болон АНУ-д суралцаж байсан. Англи хэлний өндөр мэдлэгтэй. Түүний урьд гүйцэтгэж байсан ажлын туршлагыг үндэслэн ТУЗ-ийн нарийн бичгийн даргын үүргийг маш өндөр түвшинд сайн гүйцэтгэнэ хэмээн үзэж нэр дэвшүүлж байна. Одоо саналаа хураацгаая.

ТУЗ-ийн гишүүд: 100% зөвшөөрөв.

ТУЗ-ийн дарга Эльер Хасанов:

- Одоо бүгдээрээ гуравдугаар асуудал болох ТУЗ-ийн хороодыг байгуулах, хороодын дарга болон гишүүдийн томилох талаар хэлэлцэе.

Гүйцэтгэх Захирал М.Товшин:

- Аудитын хорооны дарга хараат бус гишүүн байсан нь дээр байх гэж бодож байна. Өнгөрсөн жил Д.Үнэнбат даргалж байсан. Энэ жил Д.Үнэнбатыг мөн Аудитын хороог удирдуулах хүсэлтэй байна. Мөн Ц.Мэндбаяр, Б.Өлзийбаярыг нэр дэвшүүлэх саналтай байна. Та бүхэн юу гэж бодож байна?

ТУЗ-ийн гишүүн Г.Оюунболд:

- Б.Өлзийбаяр маань Хувьцаат компаниудын дотоод хяналтын асуудлууд дээр туршлагатай. Д.Үнэнбат бол санхүү, нягтлан бодох бүртгэлийн тал дээр мэргэшсэн. Ц.Мэндбаяр төсөл санхүү, үл хөдлөх хөрөнгийн тал дээр нэлээд туршлагатай учир шинэ санаа оноо дэвшүүлэх, аудитын тал дээр зөвлөмж өгөх боломжтой. Тиймээс надад татгалзах зүйл алга. Гэхдээ аудитын хорооноос дор хаяж зургаан сард нэг удаа дүгнэлт гаргаж өгөхийг хүсмээр байна. Учир нь ямар нэгэн асуудал, зөрчил дутагдал илэрвэл бүгдээрээ шуурхай хэлэлцэж алдаагаа засан, зөвлөмж, зөв шийдвэр гаргах боломжтой юм.

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- За одоо бүгдээрээ саналаа хураацгаая.

ТУЗ-ийн гишүүд: 100% зөвшөөрөв.

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- Нэр дэвшүүлэх хороонд Д.Үнэнбат, Ц.Мэндбаяр, даргаар Камолиддин Талиповыг нэр дэвшүүлэх хүсэлтэй байна. Нэр дэвшүүлэх хороо нь гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн гишүүдийг сонгох үүрэгтэй байдаг.

ТУЗ-ийн гишүүд: 100% зөвшөөрөв.

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- Цалин урамшууллын хорооны тухайд даргаар Эльер Хасанов, С.Батбилэг, Д.Үнэнбат нарыг гишүүдээр сонгохоор нэр дэвшүүлж байна. Эльер Хасановын хувьд хүний нөөцийн чиглэлээр арвин их туршлагатай учраас энэхүү хороог удирдаасай хэмээн хүсэж байна. Мөн цалин урамшуулал, мөнгө төгрөгтэй холбоотой учир мэргэжлийн үүднээс Д.Үнэнбатыг энэхүү хороонд нэр дэвшүүлж байгаа юм.

ТУЗ-ийн гишүүд: 100% зөвшөөрөв.

ТУЗ-ийн дарга Эльер Хасанов:

- ТУЗ-ийн хороодыг байгуулах, хороодын дарга болон гишүүдийн томилох асуудал шийдэгдсэн учир дараагийн компанийн гүйцэтгэх захирлыг томилох асуудалд орцгооё. Одоогоор “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн гүйцэтгэх захирлын албыг М.Төвшин хашиж байгаа билээ. М.Төвшингийн хувьд энэхүү компанийг зөв удирдан залж, шинэ шатанд авчирч байгаагийн хувьд миний зүгээс М.Төвшинг улируулан томилж ажилуулах саналыг дэвшүүлж байна.

ТУЗ-ийн гишүүд: 100% зөвшөөрөв.

ТУЗ-ийн дарга Эльер Хасанов:

- Та бүхэнд өөр асуух асуудал байна уу?

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- 2015 оны 4 сарын 30-нд хуралдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн оноосон нэрийг “Фронтинер Лэнд Групп” болгон өөрчлөхийг хувьцаа эзэмшигчид 100% дэмжсэн. “Монголиа Девелопмент Ресорсес” нэр нь зөвхөн Монголд мөн түүнчлэн ашигт

малтмалын үйл ажиллагаа явуулдаг гэх өрөөсгөл ойлголтыг гадны хөрөнгө оруулагчид, сангууд, хувьцаа эзэмшигчдэд төрүүлж байгаа тул компанийн цаашдын үйл ажиллагааны чиглэл цар хүрээнд тохируулан оноосон нэрээ “Фронтнер Лэнд Групп” болгон өөрчлөхөөр болсон. Энэхүү оноосон нэрийг өөрчлөх асуудлын талаар энэ сардаа багтаан холбогдох эрх бүхий байгууллагууд болон Санхүүгийн Зохицуулах Хороонд материалаа өгөхөөр шийдвэрлэсэн.

- Мөн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар 20 тэрбум төгрөг хүртэлх хувьцаа гаргахаар шийдвэрлэсэн. Хувьцааны нэрлэсэн үнийг бууруулж асуудлыг шийдэх талаар хувьцаа эзэмшигчид маань санал гаргасан байгаа. Учир нь манай компани нь анх хувьцаагаа 1000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй гаргаж байсан. Одоо манай хувьцааны ханш 500 төг байна. Компанийн тухай хуулд зааснаар компани нь нэмэлт хувьцаа гаргах тохиолдолд нэрлэсэн үнээс доогуур худалдаж болохгүй гэж дурдсан байдаг. Шинээр 1000 төгрөгөөр хувьцаа гаргахад зах зээл дээр 500 төгрөгөөр худалдаалагдаж байгаа хувьцааг хэн ч худалдаж авахгүй нь ойлгомжтой. Тиймээс нэрлэсэн үнээ буулгах арга байна. Энэ нь хөрөнгө оруулагч / хувьцаа эзэмшигчдэд ямар нэгэн хохиролгүй юм. Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрвөл шинээр хувьцаа гаргах ажил маань хийгдэж эхлэх юм. Хэрвээ Санхүүгийн Зохицуулах Хороо нэрлэсэн үнийг буулгах хувилбарыг зөвшөөрөхгүй бол ТУЗ-д өгсөн эрхийнхээ дагуу өөр ямар арга зам, боломжит хувилбар байх талаар шийднэ.

ТУЗ-ийн гишүүн Г.Оюунболд:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрээр ТУЗ-д бүрэн эрх, үүргийг өгсөн байгаа. Санхүүгийн Зохицуулах Хороо зөвшөөрөхгүй бол Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг дахин зарлахын тулд бид доод тал нь 45 хоногийн хугацаа алдагдана. Тиймээс хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас нэрлэсэн үнэ буулгах, хувьцаа хуваах, хувьцааг нэгтгэх ямар боломжит арга замаар шийдвэрлэхийг ТУЗ-д бүрэн эрхийг өгөв гэсэн тогтоол гарсан. Нэмэлт хувьцаа гаргах тал дээр нягтлан бодох бүртгэлийн талаас зөвлөмж зөвлөгөө маш их хэрэгтэй байгаа учраас Д.Үнэнбат, Д.Батсайхан нарыг энэ тал сайн оролцож ажиллаасай хэмээн албан ёсоор хүсэж байна. Андеррайтерийн талаас манай “Евразиа Капитал Холдинг” ХК хийж гүйцэтгэнэ. Компаний оноосон нэрийг солих асуудал энэ сардаа шийдэгдэх байх гэж найдаж байна. Үүний дараа бид нэмэлт хувьцаа гаргах асуудлын талаар ахин хэлэлцэнэ. Энэ жил би хурлыг олон хийх саналтай байна. Дүрэмд зургаан сард нэг удаа гэсэн байдаг. Гэхдээ бидэнд шийдэх, хэрэгжүүлэх асуудал олон байгаа учир болж өгвөл энэ жил ойр ойрхон хийвэл зүгээр байх.

Мөн энэ жил ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацааг 2 жилээр сунгасан байгаа. Урьд нь 1 жил байсан. 1 жил байна гэдэг хангалттай хугацаа биш, илүү үр дүнтэй, үр бүтээлтэй ажиллаасай гэдэг үүднээс 2 жил болгосон.

ТУЗ-ийн гишүүд: Тэгье. Санал нэгтэй байна.

Гүйцэтгэх Захирал М.Төвшин:

- Өөр нэг хэлэлцэх асуудлын тухайд – Манай компани Өмнөговь аймгийн Даланзадгад суманд 2700 метр квадрат газрыг 2011 оноос хойш эзэмшиж байна. Үнийг нягтлан бодох бүртгэлийн хувьд дуусаагүй үйлдвэр дансанд бүртгэсэн. Гол асуудал нь энэ газрыг хувь хүний нэр дээр авахаас өөр аргагүй байсан учраас Р.Ганбаатарын нэр дээр авсан. Газар

эзэмших биш газар өмчлөх эрхийн гэрчилгээ юм. Энэ утгаараа хуулийн этгээд рүү шилжих боломжгүй. Р.Ганбаатарын тухайд өөр хүний нэр рүү шилжүүлж өгөөчэй гэсэн хүсэлтийн дагуу нэр шилжүүлэх шаардлага гарсан. Энэ удаадаа манай компанийн ерөнхий нягтлан бодогч Д.Батсайхан руу шилжүүлэе гэсэн саналыг дэвшүүлмээр байна.

Энэхүү газар маань сумынхаа төвтэй ойрхон байрладаг. Бид энэхүү талбайд 6 давхар оффис үйлчилгээний барилга барих төлөвлөж, зураг төслийг нь хийлгүүлэхээр зэхсэн байгаа. Харин энэ газарт маань айлууд нүүж ороод байгаа гэсэн асуудал гарсан. Тиймээс бид энэ зундаа багтаан нэн яаралтай хашаа барих хэрэгтэй байна. Д.Батсайханы нэр дээр шилжүүлэе гэдэгт санал хураацгаая.

ТУЗ-ийн гишүүд: Санал нэгтэй байна.

Ийнхүү хурлаар бүх асуудлуудыг хэлэлцэж дууссаны дараа хурлаас гарч буй асуудал тус бүр дээр тогтоолын төслийг ТУЗ-ийн гишүүн Г.Оюунболд ТУЗ-ийн гишүүдэд уншиж танилцуулан хуралтай холбоотой бүх бичиг баримтыг зохих журмын дагуу Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид хүргүүлэх болохыг мэдэгдэн хурлыг албан ёсоор 12 цаг 05 минутанд хаав.

ТУЗ-ийн дарга:



Handwritten signature of Elver Hasanov

Эльер Хасанов

Тэмдэглэл хөтөлсөн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга:

Handwritten signature of X. Amgalanbilэг

Х.Амгаланбилэг

ТУЗ-ийн гишүүд:

- 1. Г.Оюунболд
- 2. Б.Өлзийбаяр
- 3. М.Төвшин
- 4. Д.Үнэнбат
- 5. Камолиддин Талипов
- 6. С.Батбилэг
- 7. Д.Батсайхан
- 8. Ц.Мэндбаяр

Handwritten signatures of the board members corresponding to the list above.